

**УЛААНГОМ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 6 ДУГААР СУРГУУЛЬ**

Огноо:2018.12.03

**Үдийн цай хөтөлбөр худалдан авах**

**ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Тендер  
шалгаруулалт/**

**Үдийн цай хөтөлбөрт бараа бүтээгдэхүүн  
нийлүүлэх**

**Гэрээний нэр,  
дугаар:**

**Үдийн цай хөтөлбөр, УВ6С/201801**

# ÒÁÍ ÄÄÐÈÉÍ ÓÐÈËÄÄ

**Óäñ àèí äèéí Óèààí äí ì ñòí ù í** Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль нь эрх бүхий тендерт оролцогчдоос “**Үдийн цай**” ө°ò°èá°ðèéí ò¿ðýýí ä ø ààðäèäààèé á¿òýýäýò¿¿í èéä нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна. Тендер нь дараах áäãäàñ á¿ðäýí ý.

**¿í ä:**

- 1 áäã : Äóðèèàí á¿òýýäýò¿¿í
- 2 áäã : Жимс жимсгэнэ
- 3 багц: Сүү сүүн бүтээгдэхүүн

Үнийн саналыг **2019.01.14 -ний өдрийн 10 цагт Ерөнхий боловсролын 6 дугаар ñóðäóóèèéí 214 ò î î ò °ð°í ä í ýýí ý.**

**Òáí äðèéí ò î äðóóèää :** ãèéí òàé ò°èá°ðèéí ò¿ðýýí èé үзэсгэлэн Ерөнхий боловсролын 6 дугаар ñóðäóóèèéí òí î éí ù çàèèáí ä 2019.01.14- í ìý 14.00 òäãò ýääãäáí à.

Í ðí èõí ò ò¿ñýèò ýé éí ì î áí èóäü ä óðüæáàéí à

Ñí í èðõí í ýðäýýä òáí ääðèéí áàðèè ò àè÷æéä [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтад хандаж авна уу.  
Тендерийн баримт бичгийг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50000 төгрөгөөр худалдан авна.

**Хаяг.Увс Улаангом сум 9-р баг Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн çàðèðääà**

**Óò àñ: 99458044. 99452191**

## ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

### А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

<b>1.Тендерийн цар хүрээ</b>	<p>1.1. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (цаашид ТШӨХ гэж товчлох)-д тодорхойлсон захиалагч (цаашид “захиалагч” гэх) нь энэ тендерийн баримт бичгийн ТШӨХ болон техникийн тодорхойлолтод заасан бараа, материал болон тоног төхөөрөмж (цаашид “бараа” гэх) худалдан авах тухай гэрээ байгуулахаар энэхүү тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна.</p> <p>1.2. Тендер шалгаруулалт нь ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд нэг багцтай байна.</p> <p>1.3. Олон багцтай тендер шалгаруулалтын тендерийн баримт бичгийг багц тус бүрээр үнэлж зарахыг хориглоно.</p> <p>1.4. Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн барааг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанд, газарт хүргэх үүрэгтэй.</p>
<b>2.Санхүүжил-тийн эх үүсвэр</b>	<p>2.1. Захиалагч дээр дурдсан барааг ТШӨХ-д тодорхойлсон эх үүсвэрээр санхүүжүүлнэ.</p>
<b>3.Залилан мэхлэх болон авлигын үйлдэл</b>	<p>3.1. Төрийн албан хаагч болон тендерт оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч бүр худалдан авах ажиллагаанд оролцож гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой.</p> <p>3.2. Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч нь Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй.</p>
<b>4.Эрх бүхий тендерт оролцогч</b>	<p>4.1. Тендерийн урилга нь сонирхсон этгээд бүрт нээлттэй. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч болон түүний түншлэлийн гишүүн бүр нь аль ч улсын харъяалалтай байж болно.</p> <p>4.2. Дараах тохиолдолд тендерт оролцогч (түншлэлийн гишүүн бүрт нэгэн адил хамаарна)-ийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:</p> <p>4.2.1. Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;</p> <p>4.2.2. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;</p> <p>4.2.3. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь бүтэц, зохион байгуулалт болон санхүүгийн хувьд захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг бол;</p>

- 4.2.4. Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон;
- 4.2.5. Тендерт оролцогч (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;
- 4.2.6. Илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг эрх бүхий байгууллага тогтоосон;
- 4.2.7. Сүүлийн 3 жилийн хугацаанд Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон;
- 4.2.8. Энэхүү тендер шалгаруулалтад оролцож байгаа хоёр буюу түүнээс дээш тооны тендерт оролцогчийн хууль ёсны төлөөлөгч нь нэг этгээд бол;
- 4.2.9. Энэхүү тендерийн баримт бичгийн ТООЗ-ны 14 дүгээр зүйлд хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд тендерт оролцогч нэгээс дээш тендер ирүүлсэн бол;(Гэвч энэхүү заалт нь аливаа этгээдийг нэгээс дээш тендерт туслан гүйцэтгэгчээр оролцохыг, эсхүл нэг тендер шалгаруулалтад нэгээс олон багцад тендер ирүүлэхийг хязгаарлахгүй)
- 4.3. Тендерт оролцогч 4.2.1 - 4.2.9-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу тендерт оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.

## **5. Эрх бүхий бараа**

- 5.1. Гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно. Захиалагч төлбөрийг зөвхөн ТООЗ-ны 1.1-д дурдсан барааг хүлээн авснаар төлнө.
- 5.2. Энэхүү зааварчилгааны 5.1-д дурдсан барааны гарал үүсэл гэдэгт тухайн барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн улс орон буюу газар нутгийг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.

## **6. Түншлэл**

- 6.1. Хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээд хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендерт оролцогч /цаашид талуудыг хамтад нь “түншлэл”, тус бүрийг нь “түншлэлийн гишүүн” гэх/ болж тендер ирүүлэх тохиолдолд ТШӨХ-д өөрөөр заагаагүй бол дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- (а) түншлэлийн бүх гишүүний хувьд тендер хүчин төгөлдөр байхаар тендерт гарын үсэг зурсан байх;
- (б) ТООЗ-ны 1.1-д заасан бараа нийлүүлэх гэрээг хэрэгжүүлэхэд бүх гишүүн хамтран болон тус тусдаа хүлээх хариуцлагыг тодорхойлж хамтран ажиллах гэрээнд тодорхойлсон байх;
- (в) түншлэлийн аль нэг болон бүх гишүүний нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авахад тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилох;
- (г) нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөр тооцоогзөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй харилцаж, гүйцэтгэх тухайхамтран ажиллах гэрээгээр зохицуулсан байх;
- (д) түншлэлийн гэрээний хувийг тендерийн хамт ирүүлэх.

## Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

- 7.Тендерийн баримт бичгийн агуулга**
- 7.1. Тендерийн баримт бичиг нь дор дурдсан бүлгүүдийг агуулсан 3 хэсэг баримт бичиг болон ТООЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу хийсэн нэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ. Үүнд:
- I ХЭСЭГ
- Бүлэг 1. Тендерт оролцогчид өгөх зааварчилгаа  
Бүлэг 2. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт  
Бүлэг 3 Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт  
Бүлэг 4. Тендер шалгаруулалтын маягт
- Тендерийн маягт
  - Үнийн хуваарь
  - Тендерийн баталгааны маягт
  - Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн зөвшөөрлийн маягт
- II ХЭСЭГ
- Бүлэг 5. Бараа нийлүүлэлтэд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолт
- III ХЭСЭГ
- Бүлэг 6. Гэрээний ерөнхий нөхцөл  
Бүлэг 7. Гэрээний тусгай нөхцөл  
Бүлэг 8. Гэрээний маягт
- Гэрээний маягт
  - Гүйцэтгэлийн баталгааны маягт
  - Урьдчилгаа төлбөрийн баталгааны маягт
- Хавсралт: Тендерийн урилга
- 7.2. Захиалагчийн нийтэлсэн тендерийн урилга нь тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.
- 7.3. Тендерт оролцогч тендерийн баримт бичиг дэх бүх зааварчилгаа, нөхцөл, маягт болон техникийн тодорхойлолтыг нягталж үзэх нь зүйтэй. **Тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлэхгүй байх, маягтыг дутуу бөглөн ирүүлэх нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болж болно.**
- 8.Тендерийн баримт бичгийг тодруулах**
- 8.1. Тендерт оролцохыг сонирхогч нь тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоо (“утсан холбоо”-нд зөвхөн телекс болон факсыг хамруулна)-гоор ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар ирүүлнэ. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ТШӨХ-д заасан хоногийн өмнө хүлээн авсан хүсэлтэд хариу өгнө.
- Хүсэлтийн агуулга, түүнд өгөх захиалагчийн хариуг хүсэлтийн эх сурвалжийг дурдалгүйгээр тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ.
- 8.2. Тухайн тодруулгын үр дүнд захиалагч тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл энэхүү ТООЗ-ны 9дүгээр зүйл, 24.2 дахь хэсэгт заасан журмыг баримтална.

- 9. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах**
- 9.1. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 9.2. Ийнхүү оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ. Тендерт оролцогч нэмэлт өөрчлөлт тус бүрийг хүлээн авсан тухайгаа захиалагчид утсан холбоогоор мэдэгдэх үүрэгтэй.
- 9.3. Тендерийн баримт бичигт орсон нэмэлт, өөрчлөлтийн улмаас тендер зайлшгүй өөрчлөгдөх ба уг өөрчлөлтийг бэлтгэхэд шаардагдах хангалттай хугацаа тендерт оролцогчид олгох шаардлагатай гэж үзвэл захиалагч 24.2-т заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгаж болно.

## В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

- 10. Тендер шалгаруулал-тад оролцох зардал**
- 10.1. Тендерт оролцогч тендер бэлтгэх, захиалагчид ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө бүрэн хариуцах бөгөөд захиалагч ямар ч нөхцөлд энэхүү зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.
- 11. Тендерийн хэл**
- 11.1. Тендер, түүнчлэн тендертэй холбоотойгоор захиалагч тендерт оролцогчийн хооронд харилцаж буй албан бичиг, захидлууд болон бусад баримт материалыг тендерт оролцогчид өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх баримт бичиг нь монгол хэл дээр, гадаадын этгээд худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй бол тэдгээр нь ТШӨХ-д заасан хэл дээр байна. Тендерийн баримт бичгийн монгол хэл дээрх хувь гадаад хэл дээрхтэй зөрчилдвөл монгол хэл дээр бэлтгэсэн ТББ-ийн заалтыг баримтална.
- 11.2. Аливаа тендерийг дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн тендерт холбогдох хэсгийг ТӨӨЗ-ны 11.1-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг тендерт оролцогч давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд уг орчуулгыг тендерийг хянан үзэх, үнэлэхэд харгалзана.
- 12. Тендерийн иж бүрдэл**
- 12.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
- (а) ТӨӨЗ-ны 13, 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн **тендерийн маягт болон үнийн хуваарь;**
  - (б) захиалагч шаардсан бол ТӨӨЗ-ны 21 дүгээр зүйлд заасны дагуу ирүүлэх **тендерийн баталгаа;**
  - (в) тендерт оролцогчийг төлөөлж ТӨӨЗ-ны 22 дугаар зүйлд заасны дагуу тендерт гарын үсэг зурах этгээдийн **гарын үсгийг баталгаажуулж гаргасан итгэмжлэл;**
  - (г) тендерт оролцогчийг тухайн тендерт оролцох эрх бүхий гэдгийг тогтооход шаардлагатай ТӨӨЗ-ны 17 дугаар зүйлд заасан нотлох баримтууд;
  - (д) **тендерт оролцогч нь тухайн гэрээг хэрэгжүүлэх чадвартай болохыг тогтооход шаардлагатай ТӨӨЗ-ны 18 дугаар зүйлд заасан нотлох баримтууд;**
  - (е) **нийлүүлэх бараа болон түүнийг дагалдах үйлчилгээ нь тендерийн баримт бичигт нийцэж буйг баталгаажуулсан ТӨӨЗ-ны 19 дүгээр зүйлд заасан нотлох баримт;**

- (ё) ТШӨХ-д шаардсан ТООЗ-ны дагуу бэлтгэж ирүүлэхбусад материал.
- 13. Тендерийн маягт болон үнийн хуваарь**
- 13.1. Тендерт оролцогч нь Бүлэг 4-т заасан тендерийн маягтыг бөглөж ирүүлнэ. Энэхүү маягтыг бөглөхдөө түүний агуулгыг өөрчлөлгүйгээр түүнд шаардсан бүх мэдээллийг тусгана.
- 13.2. Тендерт оролцогч нь нийлүүлэх бараа болон түүнийг дагалдах үйлчилгээний үнийн хуваарийг бэлтгэн ирүүлнэ. Үнийн хуваарийг 4 дүгээр бүлэгт заасан тендер шалгаруулалтын маягтаас тохирох маягтыг ашиглан бэлтгэнэ.
- 14. Хувилбарт тендер**
- 14.1. ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн зөвхөн нэг тендер ирүүлэх ба хувилбарт тендер ирүүлэхийг үл зөвшөөрнө.
- 15. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт**
- 15.1. Тендерийн маягт болон үнийн хуваарь дахь тендерт оролцогчийн санал болгож буй үнэ болон, үнийн хөнгөлөлт нь дор тодорхойлсон шаардлагад нийцсэн байна.
- 15.2. Үнийн хуваарьт бүх багц болон нэр төрлийг үнэ тус бүрээр нь тусад нь жагсааж ирүүлнэ.
- 15.3. Тендерийн маягтад тусгасан үнэ нь аливаа үнийн хөнгөлөлтийг тооцоогүй тухайн тендерийн нийт үнэ байна.
- 15.4. Тендерт оролцогч нь аливаа нөхцөлт бус үнийн хөнгөлөлт болон түүнийг хэрэглэх аргачлалыг тендер ирүүлэх маягтад тусад нь тусгасан байна.
- 15.5. Олон улсын худалдааны EXW, CIP болон ижил төстэй бусад нөхцөлийг хэрэглэхдээ ТШӨХ-д дурдсан, Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргасан **Incoterms-ийн** хамгийн сүүлийн хувилбарыг удирдлага болгоно.
- 15.6. Нийлүүлэх барааны үнийг тендерийн маягт (Бүлэг 4)-д заасан үнийн хуваарь бүрээр гаргаж ирүүлнэ. Ингэхдээ тендерт оролцогч нь гэрээний дагуу **нийлүүлэх барааны нэгж үнэ, тухайн нэр төрлийн нийт үнэ, нийт дүн, барааны гарал үүслийн улсын нэрийг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан нэр төрөл бүрээр холбогдох үнийн хуваарьт тусгаж ирүүлнэ.** Үнийн задаргааны агуулга нь захиалагчаас тендерийг харьцуулж үнэлэх зорилгоор шаардагдана. Энэ нь санал болгосон аливаа нөхцөлөөр гэрээ байгуулах захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.
- 15.7. Гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар хураамжийг тендер хүлээж авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг үндэслэн тендерийн үнэд багтаасан байна.
- 15.8. Барааг багцалсан эсэх талаарх мэдээллийг ТООЗ-ны 1.2 дахь заалт болон түүнд харгалзах ТШӨХ-ийн заалтаас үзнэ үү. Хэрэв багцалсан бол тендерт оролцогч нэг, эсхүл түүнээс олон багцад тендер ирүүлэх эрхтэй. Аливаа багцыг хувааж дэд багц болгон тендер ирүүлэхийг хориглоно.
- 15.9. Үнийн хуваарьт дараах зүйлсийг тусад нь бичиж харуулна. Үүнд:
- (а) Монгол Улсад үйлдвэрлэгдсэн барааны хувьд:
1. **барааны EXW үнэ** (үйлдвэрийн, агуулахын, эсхүл лангууны үнийн аль тохирохыг). Энэ үнэд барааг үйлдвэрлэх, угсрахад ашигласан үйлдвэрийн, эсхүл лангууны үнээр үнэлэгдсэн эд анги, түүхий эд, үйлдвэрлэлийн бусад өртөг багтана;

2. гэрээ байгуулах эрх олгогдсоноор дотоодын бүтээгдэхүүнд ногдуулдаг нэмэгдсэн өртгийн болон бусад адилтгах албан татвар;
  3. барааг ТШӨХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардлагатай хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.
- (б) Монгол Улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд импортоор орж ирэх барааны хувьд:
1. ТШӨХ-д захиалагчийн нэрлэсэн хилийн боомт хүртэлх СИФ/СIF/ үнэ, эсхүл захиалагчийн нутаг дэвсгэр дэхь нэрлэсэн байрлал хүртэлх СИП /CIP/ үнэ;
  2. гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирэх бараанд ногдох гаалийн, нэмэгдсэн өртгийн болон бусад албан татвар;
  3. барааг орох боомтоос буюу нэрлэсэн байрлалаас ТШӨХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардагдах хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.
- (в) Монгол Улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд өмнө нь импортоор орж ирсэн барааны хувьд:
1. барааны үнэ буюу импортоор анх орж ирсэн тухайн барааны үнэ дээр үнийн нэмэгдэл/эсхүл хөнгөлөлт/, дотоодод гарсан аливаа нэмэлт өртөг, тухайн бараанд төлсөн эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татваруудыг тооцсон үнэ;
  2. импортлогдсон бараанд урьд төлсөн(нотлох баримтыг хамт ирүүлэх шаардлагатай), эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татварууд;
  3. тухайн барааг олж авахад зарцуулсан өртөг буюу энэ заалтын 1 болон 2 –ын ялгавар;
  4. гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирсэн бараанд ногдох нэмэгдсэн өртгийн болон бусад албан татвар;
  5. бараагТШӨХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардлагатай хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.
- (г) Барааны Техникийн тодорхойлолт болон холбогдох үйлчилгээний талаарх шаардлагад тодорхойлсон Дагалдах үйлчилгээний хувьд:
- Гэрээ байгуулах эрх олгогдсоноор Дагалдах үйлчилгээнд ногдох Худалдан авагч орны гаалийн, худалдааны болон бусад адилтгах албан татварыг тооцож
- (1) Дагалдах үйлчилгээг бүрдүүлж буй зүйл тус бүрийн дотоодын валютаар илэрхийлэгдэх зардлын өртөг;
  - (2) Дагалдах үйлчилгээг бүрдүүлж буй зүйл тус бүрийн гадаадын валютаар илэрхийлэгдэх зардлын өртгийг тус тус харуулна.
- 15.10. ТШӨХ-д гэрээний үнийг тохируулах нөхцөлтэй байхаар тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байна. Тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулж өөрчлөхөөр санал болгосон аливаа тендерийг ТООЗ-ны 31 дүгээр зүйлд заасны дагуу үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж, уг тендерээс татгалзана. Гэвч ТШӨХ-д үнэ тохируулахаар заасан нөхцөлд тогтмол үнэ санал болгосон тендерээс татгалзахгүй бөгөөд түүний үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэг (0)-тэй тэнцүү байна гэж үзнэ.
- 15.11. ТШӨХ-д үнэ тохируулахаар заасан бол үнэ тохируулах нөхцөл, аргачлалыг гэрээний тусгай нөхцөлд тусгана.

15.12. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

- 16. Тендерийн валют**
- 16.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дах хэсэгт заасны дагуу тендерийн үндсэн валют нь төгрөг байна.
- 17. Тендерт оролцогч эрх бүхий эсэхийг нотлох баримт**
- 17.1. Тендерт оролцогч нь эрх бүхий эсэхийг дараах мэдээлэл, нотлох баримтад үндэслэн тогтооно. Үүнд:
- (а) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар;
  - (б) тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл;
  - (в) ТШӨХ-д шаардсан бол тухайн төрлийн бараа нийлүүлэх тусгай зөвшөөрөл.
- 18. Тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт**
- 18.1. Тендерт оролцогч нь гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан захиалагчийн шаардсан чадварын шаардлагыг хангасан гэдгийг харуулах дараах мэдээллийг нотлох баримт болгон ирүүлнэ. Үүнд:
- (а) хэрэв ТШӨХ-д шаардсан бол тендерт оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг тендерт санал болгох тохиолдолд уг барааг Монгол Улсад нийлүүлэх эрх олгосон тухай үйлдвэрлэгчийн зөвшөөрлийг 4 дүгээр бүлгийн маягтаас тохирох маягыг ашиглан ирүүлнэ;
  - (б) санхүүгийн чадавхийг харуулах ТШӨХ-д заасан тоо бүхий жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан;
  - (в) гэрээг хэрэгжүүлэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл;
  - (г) тухайн тендерт оролцогчийн туршлагыг харуулах сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй гэрээний талаарх мэдээлэл;
  - (д) хэрэв ТШӨХ-д шаардсан бол Монгол Улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй тендерт оролцогч гэрээний дагуу хийгдэх засвар үйлчилгээ, техникийн тодорхойлолтод заасан сэлбэг хэрэгслийг нийлүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт тухайн этгээд өөрөө гүйцэтгэх, эсхүл уг тендерт оролцогчийн Монгол Улсад байгуулсан, эсхүл байгуулагдах төлөөлөгч биелүүлэх тухай баримт;
  - (е) захиалагч тендерт оролцогчийн харилцагч банкнаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн мэдэгдэл;
  - (ё) одоогийн ба сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл;
  - (ж) гэрээний үнийн 10-аас дээш хувьтай тэнцэх дүнтэй ажлыг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх бол түүний чадварын талаарх мэдээлэл.
- 18.2. Тендерт оролцогч ТООЗ-ны 1.1-д заасан барааг нийлүүлэх гэрээг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Үүнд:
- (а) сүүлийн 5 жилийн аль нэг жилд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ нь ТШӨХ-д заасан дүнгээс багагүй байх;

- (б) сүүлийн [ТШӨХ-д заасан тоо]жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй, доод тал нь **нэг бараа нийлүүлэх үндсэн гүйцэтгэгчээр ажилласан туршлага;**
  - (в) ТШӨХ-д заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг цаг хугацаанд нь (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах санал;
  - (г) бусад гэрээт ажилд ашиглагдах буюу ашиглаж буй хөрөнгө болон энэ гэрээний дагуу хийгдэж болох урьдчилгаа төлбөрийг оролцуулахгүйгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээл нь ТШӨХ-д дурдсан дүнгээс багагүй байх.
  - (д) сүүлийнТШӨХ-д дурдсан жилийн хугацаанд **ашигтай ажилласан байх.**
- 18.3. Тендерт оролцогч түншлэл нь 18.2(а) ба (г)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмнэ. Гэхдээ гишүүн тус бүр 18.2 (а), (б), (г) -д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байна.

Энэ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд түншлэлийг тухайн чадварын шаардлагуудыг хангаагүй гэж үзэж тендерээс нь татгалзана. ТШӨХ-д өөрөөр заагаагүй тохиолдолд тендерт оролцогч чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлоход түүний туслан гүйцэтгэгчийн ажлын туршлага, нөөц бололцоог харгалзан үзэхгүй.

Тендерт оролцогч 18.2(б) ба (в)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохдоо түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмж тооцно.

- 18.4. ТШӨХ-д тусгайлан заасан бол Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд 10 хувийн давуу эрх олгоно. Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлэхтендерт оролцогч давуу эрх эдлэх хүсэлтэй бол энэ тухайгаа нотлоход шаардлагатай баримт, материалыг тендертэй хамтирүүлэх үүрэгтэй.

**19. Нийлүүлэх бараа нь тендерийн баримт бичгийн шаардлагад нийцэж буйг нотлох баримт**

- 19.1. Тендерт оролцогч, түүний нийлүүлэх бараа нь захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолт болон стандартад нийцэж буйг нотлох баримтыг тусгайлан бэлтгэж тендерт ирүүлнэ. Нотлох баримт нь нийтлэл, зураг, өгөгдлийн хэлбэрээр байж болох ба дараах мэдээллийг агуулна. Үүнд:
- (а) барааны техникийн болон үйл ажиллагааны шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт;
  - (б) барааг [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалт. Тус жагсаалтад тэдгээрийг аль улсаас, хаанаас нийлүүлэх боломжтойг, мөн нэгж үнэ зэрэг холбогдох мэдээллийг дурдана;
  - (в) нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдэл;
  - (г) захиалагчийн техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал болон тоног төхөөрөмжийн стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд түүгээр хязгаарлагдахгүйг тендерт оролцогч анхаарч 19.1.(в)-ийн дагуу тайлбар ирүүлнэ.

Тендерт өөр стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаарыг орлуулан хэрэглэж болох бөгөөд орлуулах зүйл нь техникийн тодорхойлолтод заасантай дүйцэхүйц, эсхүл түүнээс илүү шаардлага хангасан гэдгийг тендерт оролцогч захиалагчид нотлон харуулна.

**20. Тендер хүчинтэй байх хугацаа**

20.1. Тендерийн хүчинтэй байх хугацаа нь хуульд заасан хүчинтэй байх хугацаанаас богино байх тохиолдолд захиалагч түүнийг үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж татгалзана.

**21. Тендерийн баталгаа**

21.1. ТШӨХ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч нь ТШӨХ-д заасан үнийн дүнтэй тэнцэх тендерийн баталгааг ирүүлнэ.

21.2. Тендер шалгаруулалт олон багцтай бол нэг тендерийн баталгаа гаргаж, түүнд багц тус бүрээр тодорхойлж ирүүлнэ.

21.3. Захиалагч тендерийн баталгааны хэмжээг багц тус бүрийн төсөвт өртгийн 1-2 хувиар тооцож ТШӨХ-д заана.

21.4. Тендерийн баталгаа нь Монгол Улсын, эсхүл гадаадын нэр хүндтэй банкны гаргасан баталгаа, Засгийн газрын бонд эсхүл Засгийн газраас хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр байж болно. Тендерийн баталгааг 4 дүгээр бүлэг дэх маягтаар, эсхүл тендер хүлээн авахаас өмнө захиалагч урьдчилан хүлээн зөвшөөрсөн маягтаар ирүүлнэ. Тендерийн баталгаа нь тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

21.5. Тендерийн баталгааны эх хувийг ирүүлэхдээ захиалагчийн ТШӨХ-д заасан хоног (он, сар, өдөр)-оор тооцож ирүүлнэ.

21.6. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

21.7. Энэ зүйлд шаардсаны дагуу хүлээн зөвшөөрөхүйц тендерийн баталгаа ирүүлээгүй аливаа тендерээс захиалагч үндсэн шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.

21.8. Тендер нь шалгараагүй оролцогчийн тендерийн баталгааг 20.1-д заасан тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногт багтаан хүчингүй болгоно.

21.9. Тендер нь шалгарсан оролцогчийн тендерийн баталгааг ТООЭ-ны 41 дүгээр зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зурж, ТООЭ-ны 42 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлсэн тохиолдолд хүчингүй болгоно.

21.10. Тендерийн баталгааг дараах тохиолдолд улсын орлого болгоно. Үүнд:

(а) тендер нээсний дараа тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан, эсхүл буцааж авахыг бичгээр мэдэгдсэн;

(б) тендерт оролцогч 32.2-ын дагуу тендерийн үнэд хийсэн залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд ТООЭ-ын 38.2-т заасан нөхцөл үүссэн бол;

(в) шалгарсан тендерт оролцогч заасан хугацаанд багтаан:

(1) ТООЭ-ны 41 дүгээр зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зураагүй;

(2) ТООЭ-ны 42 дугаар зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй.

**22. Тендер ирүүлэх хувь, тендерт**

22.1. Тендерт оролцогч 12 дугаар зүйлд заасан тендерийн бүрдэл баримт бичгийн эх хувиудыг бэлтгэн хавтаслаж, түүнд "ЭХ ХУВЬ" гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Тендерт оролцогч үүнээс гадна ТШӨХ-д заасан тоо ширхэг бүхий тендерийн хуулбар хувийг бэлтгэн хавтаслаж "ХУУЛБАР ХУВЬ" гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Эх хувь болон хуулбар хувиуд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд эх хувийг баримтална.

**гарын үсэг  
зурах**

- 22.2. Тендерийн эх болон хуулбар хувиудыг хэвлэж (компьютер, бичгийн машин гэх мэт), эсхүл арилдаггүй бэхээр бичиж, тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулна. Тендерт оролцогчийн боловсруулсан тендерийн агуулга, үнэтэй холбоотой **бүх хуудсанд төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурна.** Хэвлэмэл танилцуулга, тайлан болон бусад байгууллагын гаргасан албан ёсны мэдээлэл зэрэг баримт бичиг үүнд хамаарахгүй.
- 22.3. Тендер ирүүлэхээс өмнө захиалагчийн гаргасан зааварчилгаатай нийцүүлэх, эсхүл тендерт оролцогч өөрийн алдааг зайлшгүй шаардлагаар засахаас бусад тохиолдолд тендерт ямар нэг засвар, нэмэлт бичилт хийхгүй ба засвар, нэмэлт бичилт хийсэн тохиолдолд зөвхөн дээрх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар тэдгээр засвар өөрчлөлтийг хүчинтэйд тооцно.

---

**Г. ТЕНДЕР ИРҮҮЛЭХ**

---

**23. Тендерийг  
битүүмжлэх,  
бичиглэл хийх**

- 23.1. Тендерт оролцогч өөрийн тендерийг шуудангаар, эсхүл өөрийн бие төлөөлөгчөөр захиалагчид хүргүүлнэ.
- 23.2. Тендерийн эх болон хуулбар хувиудыг тус тусад нь **“ЭХ ХУВЬ”, “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн бичиглэл бүхий дугтуйнд хийж битүүмжлэн тэдгээрийг дахин давхар нэг дугтуйнд (гаднах) хийж битүүмжилнэ.** Тендерээ дугтуйлж, битүүмжлэхдээ ТӨӨЗ-ны 23.3, 23.4 –т заасныг баримтална.
- 23.3. Доторх ба гаднах дугтуйнууд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- (а) **тендерт оролцогчийн нэр, хаягтай байх;**
  - (б) **ТШӨХ-д заасан** хаягаар ТӨӨЗ-ны 1.1-т заасан **захиалагчийн нэр дээр хаяглах;**
  - (в) тендер шалгаруулалтыг таних, ялгах тэмдэг болгож ТӨӨЗ-ны 1.1 болон **ТШӨХ-д тодорхойлсон тендер шалгаруулалтын нэр/дугаарыг тодорхой бичсэн байх;**
  - (г) ТӨӨЗ-ны 28.1-т заасан хугацаанаас өмнө **“НЭЭЖ ҮЛ БОЛНО”** гэж тэмдэглэгдсэн байх.
- 23.4. Хэрэв бүх дугтуйг 23.3-т заасан шаардлагын дагуу битүүмжилж, бичиглэл хийгээгүй нөхцөлд уг тендер буруу хаягаар хүргэгдсэн, эсхүл тендер нээхээс өмнө битүүмжлэл задарсан тохиолдолд захиалагч хариуцлага хүлээхгүй.
- 23.5. ТӨӨЗ-ны 23.1-т зааснаас өөр хэлбэрээр ирүүлсэн аливаа тендерийг захиалагч хүлээж авахгүй бөгөөд түүнийг хаягаар нь буцаана.

**24. Тендер  
хүлээн авах  
эцсийн  
хугацаа**

- 24.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
- 24.2. Захиалагч ТӨӨЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсны улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд захиалагч болон тендерт оролцогчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр хадгалагдана.

- |     |  |  |
|-----|--|--|
| 25. | <b>Хугацаа хоцорсон тендер</b>                             | 25.1. Захиалагч ТООЗ-ны 24 дүгээр зүйлд заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн аливаа тендерийг <b>“хугацаа хоцорсон” гэж зарлан түүнээс татгалзаж, нээлгүйгээр буцаана.</b>   |
| 26. | <b>Тендерт оролцогч нэг этгээд нэг тендер ирүүлэх</b>      | 26.1. Аливаа этгээд дангаараа, эсхүл хамтран ажиллах гэрээний үндсэн дээр түншлэл болж тендер шалгаруулалтад оролцохдоо зөвхөн нэг тендер ирүүлнэ. Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүд нэгээс дээш тендер ирүүлсэн, бол түүний ирүүлсэн бүх тендерээс татгалзана.   |
| 27. | <b>Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах</b> | <p>27.1. Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагчид бичгээр мэдэгдэл өгсний үндсэн дээр өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, солих, эсхүл түүнийг буцааж авах эрхтэй.</p> <p>27.2. Тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, тендерийг солих эсвэл буцааж авах мэдэгдлийг 22, 23 дугаар зүйлийн дагуу бэлтгэн, битүүмжилж, бичиглэл хийхийн хамт доторх ба гаднах дугтуй дээр <b>“НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”, “ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ”, эсхүл “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ”</b> гэсэн бичиглэл хийнэ. Тендерийг буцааж авах мэдэгдлийг утсан холбоогоор ирүүлж болох ба энэ мэдэгдэл хүчин төгөлдөр болохыг батламжилж гарын үсэг, тамга бүхий эх хувийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө заавал ирүүлнэ.</p> <p>27.3. Тендер хүлээн авах эцсийн хугацаа өнгөрснөөс хойш аливаа тендерт ямар нэг нэмэлт өөрчлөлт хийх, солих, эсвэл буцааж авахыг зөвшөөрөхгүй.</p> <p>27.4. ТООЗ-ны 27.2-т заасны дагуу тендерээ буцааж авах тухай хүсэлт ирүүлсэн оролцогчийн үндсэн тендерийг нээлгүйгээр буцаан олгоно.</p> <p>27.5. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас тендер хүчинтэй байх хугацааны хооронд тендерийг буцааж авах нь 21 дүгээр зүйлийн дагуу тендерийн баталгааг улсын орлого болгох үндэслэл болно.</p> |

---

#### Д. ТЕНДЕРИЙГ НЭЭХ, ҮНЭЛЭХ

---

- |     |                       |  |
|-----|-----------------------|--|
| 28. | <b>Тендерийг нээх</b> | <p>28.1. Захиалагч тендерийн нээлтийг ТШӨХ-д заасан огноо, цагт, заасан хаяг бүхий газарт зохион байгуулна. Тендер нээх үед тендерт оролцогч, эсхүл түүний <b>төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлцах эрхтэй ба байлцсан бол тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсгээ зурна.</b></p> <p>28.2. Захиалагч эхлээд <b>“ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ”</b> гэсэн бичиглэл бүхий дугтуйг нээж, зарлах бөгөөд энэ хүсэлтийг ирүүлсэн оролцогчийн үндсэн тендерийг нээлгүйгээр буцаана. Дараа нь <b>“ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ”</b> бичиглэл бүхий тендерийг нээж зарлах бөгөөд уг тендерийг ирүүлсэн оролцогчийн урьд ирүүлсэн тендерийг нээлгүйгээр түүнд буцаан олгоно. <b>“ТЕНДЕРТ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”</b> бичиглэл бүхий дугтуйг түүнд харгалзах үндсэн тендерийн хамт нээж нийтэд зарлана.</p> <p>28.3. <b>Тендерийг нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, санал болгосон бол үнийн хөнгөлөлт, хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд түүний үнэ, тендерийн баталгаа байгаа эсэх, оролцогч өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан бол уг нэмэлт өөрчлөлтийг болон захиалагч шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэнэ.</b> Тендер нээх үед зарлагдаагүй тендерийн үнэ, үнийн хөнгөлөлт болон хувилбарт тендерийг үнэлгээнд харгалзахгүй.</p> |
|-----|-----------------------|--|

- 28.4. Захиалагч тендерийн нээлтийн тэмдэглэлийг хөтлөх бөгөөд уг тэмдэглэл нь дараах мэдээллийг заавал агуулсан байна. Үүнд:
- (a) тендерт оролцогчийн нэр болон тухайн тендерт оролцогч тендерээ буцааж авсан, эсхүл тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан буюу тендерээ сольсон эсэх;
  - (б) тендерийн үнэ болон санал болгосон үнийн хөнгөлөлт(зөвшөөрсөн бол хувилбарт тендерийн үнэ).Нэгээс дээш багцтай тендер шалгаруулалтын үед эдгээр мэдээллийг багц тус бүрээр гаргах;
  - (в) захиалагч тендерийн баталгаа шаардсан бол түүнийг ирүүлсэн эсэх.

## 29. Нууцлах

- 29.1. Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд тендерт оролцогчид болон тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй аливаа этгээдэд задруулахыг хориглоно.
- 29.2. Захиалагч тендерийг хянан үзэх, үнэлэх, харьцуулах явцад, эсхүл гэрээ байгуулах эрх олгох шийдвэрт тендерт оролцогчоос нөлөөлөх гэсэн аливаа оролдлого нь тухайн оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болно.
- 29.3. Тендерийн нээлт хийснээс хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд захиалагч болон тендерт оролцогчид хоорондоо зөвхөн бичгээр харилцана.

## 30. Тендерийг тодруулах

- 30.1. Тендерийг хянан үзэх, үнэлэх болон харьцуулах явцад тендерийг үнэлэхэд зайлшгүй шаардлагатай бол захиалагч тендерт оролцогчоос түүний тендерийн талаар тодруулга ирүүлэхийг хүсч болно. Тендерийг тодруулахтай холбоотой аливаа харилцааг бичгээр явуулна.Гэхдээ 31 дүгээр зүйлийн дагуу тендерийг хянан үзсэний үндсэн дээр захиалагчийн илрүүлсэн арифметик алдааг залруулахаас бусад тохиолдолд тендерийн үнэ болон агуулгад ямар нэг өөрчлөлт хийхийг хүсэх, санал болгохыг зөвшөөрөхгүй.

## 31. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох

- 31.1. Аливаа тендерийг нарийвчлан үнэлэхээс өмнө уг тендер нь дараахь шаардлагыг хангаж буй эсэхийг хянан үзнэ. Үүнд:
- (a) ТООЗ-ны 4 дүгээр зүйлд заасан эрх бүхий тендерт оролцогч байх шаардлагыг хангасан эсэх;
  - (б) тендерт зохих ёсоор гарын үсэг зурж, баталгаажуулсан эсэх;
  - (в) зөвшөөрөгдсөн маягтын дагуу захиалагчийн шаардлагыг хангасан тендерийн баталгаа ирүүлсэн эсэх;
  - (г) тендерийн баримт бичигт тавигдсан бусад шаардлагад нийцсэн эсэх;
  - (д) тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадварын доод шаардлагыг хангасан эсэх.
- 31.2. ТООЗ-ны 31.1 дэх заалтын (а) - (д)-д заасан заалт тус бүрийг хангаж буй тохиолдолд шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.
- 31.3. Шаардлагад нийцсэн тендер гэж тендерийн баримт бичгийн бүх нөхцөл болзол, тендерт оролцогчийн үйлдвэрлэлийн хүчин чадал, санал болгосон бараа нь ТООЗ-ны 19 дүгээр зүйлд заасаннөхцөл болон техникийн тодорхойлолтыг материаллаг

зөрүүгүйгээр хангаж буй тендерийг хэлнэ. Дор дурдсан зүйлсийг материаллаг зөрүү гэж үзнэ. Үүнд:

- (a) тендерт санал болгож буй бараа нь техникийн тодорхойлолт болон гэрээний нөхцөлд тодорхойлсон барааны хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхээр бол;
- (б) гэрээнд заасан захиалагчийн эрх, тендерт оролцогчийн үүрэгт тендерийн баримт бичигтэй үл нийцэх зарчмын хязгаарлалт оруулсан бол;
- (в) зөрүүг хүлээн зөвшөөрч засварлах буюу залруулах нь шаардлагад нийцсэн бусад тендерийн өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөх бол.

31.4. Захиалагч шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон тендерээс татгалзана. Харин тендерт оролцогч түүнд засвар хийж шаардлагад нийцсэн болгож болохгүй.

**32. Алдааг залруулах**

32.1. Захиалагч шаардлагад нийцсэн гэж тодорхойлогдсон тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна. Үүнд:

- (a) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзэж тоондүнг засварлах;
- (б) нэр төрлийн нийт үнийн нийлбэр нь тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл нэр төрлийн нийт үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулах;
- (в) нэр төрлийн нийт үнэ нь түүний нэгж үнийг тоо ширхэгээр үржүүлэхэд гарсан үнээс зөрвөл нэр төрлийн нэгж үнийг үндэслэн түүний нийт үнийг залруулна. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

32.2. Захиалагч, “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн үнэндзалруулга хийхээр байвал энэ талаар тухайн тендерт оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрсөн эсэхийг бичгээр баталгаажуулж авна.

**33. Нэг валютад хөрвүүлэх**

33.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол банкнаас албан ёсоор зөвшөөрсөн тохиолдол ТООЗ-ны 16 дугаар зүйлд зааснаас өөр валютаар тендерийн үнийг илэрхийлж болно. Ийм тохиолдолд захиалагч тендерийн үнэлгээ, харьцуулалтыг хийхдээ тендерийн үнийг тендер зарласан өдрийн Монголбанкны ханшаар төгрөгт хөрвүүлнэ.

**34. Дотоодын давуу эрх**

34.1. ЗахиалагчТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерүүдийг үнэлж харьцуулахдаа Монгол Улсын гарал үүсэлтэй бараа санал болгосон тендерт бусад гарал үүсэлтэй бараа санал болгосон тендертэй харьцуулахад давуу эрхийн зөрүү олгохгүй.

**35. Тендерийг үнэлэх, харьцуулах**

35.1. Захиалагч зөвхөн 31 дүгээр зүйлийн дагуу шаардлагад нийцсэн гэж тогтоогдсон тендерийг үнэлж, харьцуулна.

35.2. Захиалагч тендерийг үнэлэхдээ дараах байдлаар тендерийн үнэд залруулга хийж, тендерийн харьцуулах үнийг тодорхойлно. Үүнд:

- (a) ТООЗ-ны 32 дугаар зүйлийн дагуу арифметик алдааг тооцож тендерийн үнийг залруулах;

- (б) ТООЗ-ны 31.3дугаарзүйлийн дагуу томоохон зөрүү гэж тооцоогүй бага хэмжээний орхигдуулсан зүйл буюу тоо хэмжээний зөрүүг тооцон мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэд залруулга хийх;
  - (в) тендерт оролцогчийн санал болгосон нэмэлт өөрчлөлт буюу үнийн хөнгөлөлтийг тусгах;
  - (г) захиалагч энэ тендерийн баримт бичгийн 3 дугаар бүлэг буюу үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг түүнд холбогдох аргачлалын дагуу тооцон мөнгөөр илэрхийлж, түүнийг тендерийн үнэд нэмж тооцох;
  - (д) ТШӨХ-д зөвшөөрсөн бол дотоодын давуу эрхийн зөрүүг холбогдох аргачлалын дагуу тооцох.
- 35.3. Шаардлагад нийцсэн тендерүүдийг 35.2-т заасны дагуу үнэлгээ хийж тендер тус бүрийн харьцуулах үнийг тогтооно. Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж шалгаруулна.
- 35.4. ТШӨХ-д заасны дагуу хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд “хамгийн сайн” үнэлэгдсэн үндсэн тендерийн хувилбарт тендер үндсэн тендерээс илүү нөхцөл хангасан бол хувилбарт тендерийг шалгаруулна.
- 35.5. Барааг ТООЗ-ны 1.2 дахь хэсэгт хоёр буюу түүнээс дээш багцад хуваасан бол захиалагч үнэлгээг багц тус бүрт хийх бөгөөд харин гэрээ байгуулах эрх олгохдоо нэг багц, хэд хэдэн багц, эсхүл бүх багцын аль үр ашигтай хувилбарыг сонгож болно.
- 35.6. Олон багцтай тендер шалгаруулалтад “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийг шалгаруулж, тэдгээрт гэрээ байгуулах эрх олгох хамгийн үр ашигтай хувилбарыг сонгохдоо захиалагч 3 дугаар бүлэг буюу үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт дэхь олон багцтай тендерийг үнэлэх тухай тусгайлан заасан аргачлалыг мөрдөнө.

**36. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах**

- 36.1. Захиалагч шаардлагад нийцсэн, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг дахин магадлаж болно.
- 36.2. Тендерт оролцогчийн чадварыг тодорхойлохдоо ТООЗ-ны 18.1-д заасны дагуу тендерт оролцогчийн ирүүлсэн чадварыг нотлох баримт болон ТООЗ-ны 30 дугаар зүйлийн дагуу хийсэн шаардлагатай нэмэлт тодруулгад үндэслэн ТООЗ-ны 18.2-т заасан чадварын шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлно. Захиалагч 18.2 болон тендерийн үнэлгээнд харгалзах чадварын шалгуур үзүүлэлтэд заагаагүй бусад шалгуур үзүүлэлтийг тендерийг хянан үзэх, тендерт оролцогчийн чадварыг тогтооход ашиглахгүй.
- 36.3. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаад, шаардлага хангасан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгоно. Хэрэв шаардлага хангахгүй бол уг тендерээс татгалзан сайн гэж үнэлэгдсэн дараагийн тендерт оролцогчийн чадварыг мөн адил зарчмаар магадлана.

**37. Аливаа тендерийг сонгох, эсхүл тендерүүдээс татгалзах захиалагчийн эрх**

- 37.1. Захиалагч тендер шалгаруулалтыг үндэслэлгүйгээр хүчингүй болгохыг хориглоно.

---

## E. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ

---

<b>38. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур</b>	<p>38.1. Захиалагч шаардлагад нийцсэн бөгөөд 35.3-т заасны дагуу “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.</p> <p>38.2. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч ТӨӨЗ-ны 32 дугаар зүйлийн дагуу захиалагчийн залруулсан арифметик алдааг хүлээн зөвшөөрөөгүй бол гэрээ байгуулахаас татгалзсан гэж тооцож, тендерээс татгалзах бөгөөд 21.9(б)-д заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгоно.</p>
<b>39. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл</b>	<p>39.1. Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгох шийдвэрээ гаргаж тендер нь шалгарсан оролцогч болон бусад тендерт оролцогчид нэгэн зэрэг бичгээр хүргүүлнэ.</p> <p>39.2. Шалгарсан тухай мэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэх бараанд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.</p> <p>39.3. Гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг мэдээлсний дараа шалгараагүй тендерт оролцогч өөрийн тендерийн үнэлгээний талаар тайлбар авах хүсэлтийг бичгээр гаргаж болно. Хүсэлт гаргасан тохиолдолд захиалагч бичгээр хариу өгнө.</p> <p>39.4. Тендер нь шалгарсан оролцогч ТӨӨЗ-ны 42 дугаар зүйлийн дагуу гаргасан гүйцэтгэлийн баталгаа гаргаж, гэрээний маяганд гарын үсэг зурж ирүүлсэн даруй захиалагч ТӨӨЗ-ны 21.8-д заасны дагуу тендерийн баталгааг хүчингүй болгож, энэ тухайг шалгараагүй бусад тендерт оролцогчид мэдэгдэнэ.</p>
<b>40. Захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед тоо хэмжээг өөрчлөх</b>	<p>40.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх төсөл арга хэмжээний үед захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед үнэ, бусад нөхцөл болзлыг үл өөрчлөн техникийн тодорхойлолтод дурдсан барааны тоо ширхэгийг ТШӨХ-д заасан хувиар өөрчлөх эрхтэй.</p>
<b>41. Гэрээнд гарын үсэг зурах</b>	<p>41.1. Захиалагч гэрээний маягт болон талуудын хооронд тохирсон бүх нөхцөлийг тусгасан тохиролцоог гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.</p> <p>41.2. Шалгарсан тендерт оролцогч гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 5-аас дээш хоногийн дараа ТШӨХ-д тусгайлан заасан хугацаанд багтаан түүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.</p> <p>41.3. Захиалагч шалгарсан тендерт оролцогчийг гүйцэтгэлийн баталгаа ирүүлсний дараа ТӨӨЗ-ны 39.4-т нийцүүлэн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.</p>
<b>42. Гүйцэтгэлийн баталгаа</b>	<p>42.1. Гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд заасан хугацаанд багтаан, ТШӨХ, гэрээний тусгай нөхцөлд тусгайлан заасан хэлбэр, дүнгээр ирүүлнэ.</p> <p>42.2. Шалгарсан тендерт оролцогч ТШӨХ-д тусгайлан заагаагүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхгүй байж болно.</p> <p>42.3. Шалгарсан тендерт оролцогч ТӨӨЗ-ны 42.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох болон тендерийн баталгааг гүйцэтгүүлэх үндэслэл болно.</p>

---

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТӨӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТӨӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТӨӨЗ-ны холбогдох заалт	<b>А. Ерөнхий зүйл</b>
ТӨӨЗ 1.1	Захиалагч нь: <b>Увс Аймгийн Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль</b>
ТӨӨЗ 1.1	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: Үдийн цай хөтөлбөр <b>УВ6С/201801</b>
СТОӨЗ 1.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b><u>1. Сургуулийн үдийн цайнд:</u></b> <i>Нэгдүгээр багц: Гурил, гурилан бүтээгдэхүүн</i> <i>Хоёрдугаар багц: Жимс жимсгэнэ</i> <i>Гуравдугаар багц: Сүү сүүн бүтээгдэхүүн</i> <b><u>Хамрагдах сургуулийн хүүхдийн тоо:</u></b> <i>Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль -625</i>
ТӨӨЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Улсын төсөв</b>
	<b>Б. Тендерийн баримт бичиг</b>
ТӨӨЗ 8.1	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: <b>Увс аймгийн Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль</b> <b>Утас:99458044,99452191</b>
ТӨӨЗ 8.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаа ажлын <b>5 хоногоос багагүй байна.</b>
	<b>В. Тендер бэлтгэх</b>

<p><b>ТӨӨЗ 12.1</b> <b>(ё)</b></p>	<p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн 1 жилд / 2018 он/ гэрээгээр гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлэлтийн ажлын гэрээ дүгнэсэн акт, гэрээний үүргээ биелүүлсэн талаар өмнөх захиалагчийн үнэлгээ, тодорхойлолт баталгаажсан баримтууд.</li> <li>2. Тендерт оролцогчийн захирал, дарга, нягтлан бодогч, борлуулалтын менежер, мэргэжилтэн, зэрэг ажилтны мэргэжлийн үнэмлэх, дипломны хуулбар , иргэний үнэмлэх хуулбар</li> <li>3. . Ажилтны хүнс үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэжил эзэмшсэнийг гэрчлэх баримт бичиг</li> <li>5. Банкнаас хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай лавлагаа, тодорхойлолтыг тендерт авч ирүүлэх, /эх хувиар/</li> <li>6. Харьяа татвар, Нийгмийн даатгалын хэлтэс, Шүүх, ШШГБ-уудын тодорхойлолт ирүүлнэ /тодорхойлолтууд 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх,</li> <li>7. Нийлүүлэх барааны баталгаат хугацааны мэдэгдэл гаргаж ирүүлэх.</li> <li>8.. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр ирүүлэх. /Тендерт оролцогч нь үнэлгээний хорооны гишүүдэд нөлөөлөх, нөлөөлөхийг оролдсон нь баримтаар нотлогдвол тендерээс татгалзана./</li> <li>9.. Тендерт оролцогч уг тендерийн багацд шалгарсан тохиолдолд санал болгосон үнэд багтаан барааг нийлүүлж гэрээний үүргээ биелүүлэх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</li> <li>10. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулж ирүүлнэ/</li> <li>11. Ажлын байр, орчны ариун цэврийн дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар гаргуулж ирүүлэх</li> <li>12. Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын шинжилгээний дүгнэлтийн хуулбар</li> <li>13. Хүнсний бүтээгдэхүүн агуулах байрны /зоорь/ гэрчилгээний хуулбар, түрээсийнх бол 2018 оны түрээсийн гэрээний хуулбар, зураг ирүүлэх,</li> <li>14. Мэргэжлийн хяналтын газраас сүүлийн 1 жилд / 2018 он/ тавьсан акт, дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлсэн тухай баримтыг ирүүлэх</li> <li>15. Тендерт оролцогч үнийн өсөлтөөс хамаарах эрсдлийг өөрөө хариуцах тухай албан бичгээр баталгаажсан мэдэгдэл ирүүлэх,</li> <li>16. Үйлдвэрийн хүчин чадлын тодорхойлолт ирүүлэх</li> <li>17. <b>Стандарт хэмжилзүйн хэлтсийн баталгаажуулалтанд хамрагдаж тохирлын гэрчилгээ авсан байх / хугацаа дуусаагүй /</b></li> <li>18. . Тендерт оролцогчийн багаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалт</li> <li>19.. Хүнсний үйлдвэрлэл явуулах зөвшөөрөл,</li> <li>20. Бүтээгдэхүүний жагсаалт, бүтээгдэхүүн тус бүрийн орц, норм ,үнийн санал</li> <li>21. .Тухайн бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх <b>зориулалтын тээврийн хэрэгсэлийн бичиг баримт, фото зураг</b></li> <li>22. Ажилчдын эрүүл мэндийн байдлыг тодорхойлсон мэргэжлийн байгууллагын үзлэг, шинжилгээний бичиг ирүүлэх.</li> <li>23. Ажлын байрыг үзэж үнэлгээнд оруулах</li> <li>24. <b>Дээрх материалуудыг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</b></li> </ol>
<p><b>ТӨӨЗ 14.1</b></p>	<p>Хувилбарт тендер ирүүлэхийг <b>“зөвшөөрөхгүй”</b>.</p>
<p><b>ТӨӨЗ 15.5</b></p>	<p>Олон улсын худалдааны Incoterms/Инкотермс -ийн хувилбар:<b>хэвлэгдсэн оныг нь оруул. :“Incoterms 2009”</b></p>
<p><b>ТӨӨЗ 15.9</b> <b>(б) (1) and (в)</b> <b>(3)</b></p>	<p>Бараа хүргэгдэх газар: <b>Увс Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль</b></p>

ТӨӨЗ 15.9 (а) (3);(б)(3) болон (в)(5)	“Бараа хүргэгдэх эцсийн цэг (Захиалагчийн агуулах, эсхүл барааг эцсийн хэрэглэгчид хүргэх байршил)”: <i>Гэрээнд заасан хуваарийн дагуу шалгарсан оролцогчид багц тус бүрийн барааг захиалагчийн заасан газарт нийлүүлэх үүрэг хүлээнэ.</i>
ТӨӨЗ 15.9 (б) (1)	Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь ТӨӨЗ-ны 15.9.(б).(1) дэх хэсэгт заасан захиалагчийн нутаг дэвсгэр дэхь нэрлэсэн байрлал хүртэлх СИП / СІР үнэ байна.
ТӨӨЗ 15.10	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад <b>“<i>тогтмол байна</i>”</b>
ТӨӨЗ 16.1	Тендерийн валют: <b><i>Төгрөг байна.</i></b>
ТӨӨЗ 18.1 (а)	Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: “шаардлагатай” <i>Тендерт оролцогч тухайн барааны үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн зөвшөөрлийн хуулбарыг ирүүлнэ, Санал болгож буй барааны гарал үүслийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ.</i>
ТӨӨЗ 18.1 (б)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: <b><i>2017 оны жил эцсийн тайлан аудитын байгууллагаар баталгаажуулсан</i></b>
ТӨӨЗ 18.1 (г)	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: <b><i>Сүүлийн 2 жил тухайн бараатай ижил төстэй нийлүүлэлт хийж байсан талаар мэдээлэл ирүүлэх /ижил төстэй бараа нийлүүлж байсан талаархи гэрээний хуулбарыг ирүүлэх /МАЯГТ №: ТШМ-5Б дагуу ирүүлнэ.</i></b>
ТӨӨЗ 18.1 (д)	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ:
ТӨӨЗ 18.2 (а)	Борлуулалтын хэмжээ: <b><i>Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 он. Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн дундаж нь гэрээний үнийн дүнгийн 70% иас багагүй байна.</i></b>
ТӨӨЗ 18.2 (б)	Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: <b><i>2 жил</i></b>
ТӨӨЗ 18.2 (в)	Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: <b><i>Шаардлагатай:</i></b> <b><i>Үүнд:</i></b> <b><i>1.Тээврийн хэрэгсэл-1, Хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалтын шаардлага хангасан байна.</i></b> <b><i>2.жин хэмжүүр-1, баталгаажсан байна.</i></b> <b><i>3.зоорь, агуулах –стандартын шаардлага хангасан байна.</i></b> <b><i>Эдгээрийн гэрчилгээний хуулбар, зураг зэргийг ирүүлж нотлоно.</i></b>

	Агуулах байрны гэрчилгээний хуулбар, түрээсийнх бол <b>2018 оны түрээсийн гэрээг ирүүлэх.</b>
ТӨӨЗ 18.2 (г)	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: <b>Гэрээний үнийн дүнгийн 30%-иас багагүй. Санхүүгийн чадавхийн талаархи мэдээллийг МАЯГТ №: ТШМ-5Г дагуу ирүүлнэ</b>
ТӨӨЗ 18.2 (д)	Ашигтай ажилласан байх жилийн тоо: <b>Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 онуудад ашигтай ажласан байна</b>
ТӨӨЗ 18.4	Дотоодын давуу эрхийн зөрүү: <b>"тооцохгүй"</b>
ТӨӨЗ 19.1.(б)	Барааг тасралтгүй горимын дагуу ашиглах, эсхүл ажиллуулахаар тооцоолж буй хугацааны үе (энэ хугацаанд шаардагдах сэлбэг хэрэгслийг тооцоолох зорилготой): <b>1 жил</b>
ТӨӨЗ 20.1	Тендер нээснээс хойш <b>45</b> хоногийн туршид хүчинтэй байна.
ТӨӨЗ 21.1	Тендерийн баталгааны үнийн дүн:
ТӨӨЗ 22.1	Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: <b>0 хувь</b>
	<b>Г. Тендер ирүүлэх</b>
ТӨӨЗ 23.3 (б)	Тендер хүлээн авах захиалагчийн хаяг: Тендер хүлээн авах этгээд: <b>Нягтлан бодогч В.Оюунцэцэг</b> Байгууллагын хаяг: <b>Увс аймгийн Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль</b> Давхар болон өрөөний дугаар: <b>2 давхар 214 тоот өрөө</b> Аймаг, хот: <b>Увс Улаангом хот</b> Шуудангийн дугаар: <b>Үгүй</b> Улс: <b>"Монгол Улс" Увс аймаг</b>
ТӨӨЗ 23.3 (в)	Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн гаднах болон доторх дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ: <b>Үдийн цай хөтөлбөр УВ6С/201801</b>
ТӨӨЗ 24.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <b>2019 оны 01 дугаар сарын 14-ны өдөр</b> Цаг: <b>09 цаг 00 минутад</b>

<p><b>ТӨӨЗ 28.1</b></p>	<p style="text-align: center;"><b>Д. Тендерийг нээх, үнэлэх</b></p> <p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:  Байшин, гудамжны нэр: <b>Увс аймаг Улаангом сумын 9-р баг</b>  Давхар болон ерөөний дугаар: <b>Увс аймаг Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2 давхар 214 тоот өрөө</b>  Аймаг, хот: <b>Увс аймаг. Улаангом хот</b>  Шуудангийн дугаар: <b>Үгүй</b>  Улс: <b>“Монгол Улс”</b>  Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:  Огноо: <b>2019 оны 01 дугаар сарын 14-ны өдөр</b>  Цаг: <b>10 цаг 00 минут</b></p>
	<p style="text-align: center;"><b>Е. Гэрээ байгуулах эрх олгох</b></p>
<p><b>ТӨӨЗ 40.1</b></p>	<p>Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: <b>Үгүй</b>  Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь: <b>Үгүй</b></p>
<p><b>ТӨӨЗ 42.1</b></p>	<p>Гүйцэтгэлийн баталгаа:</p>

# БАРАА НИЙЛҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

## АГУУЛГА

1. БАРААНЫ НЭР ТӨРЛИЙН ЖАГСААЛТ БОЛОН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ
2. ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВААРЬ
3. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
4. ШАЛГАЛТ БОЛОН ТУРШИЛТ

### **1. Сургуулийн үдийн цайнд:**

*Нэгдүгээр багц: Гурил, гурилан бүтээгдэхүүн*

*Хоёрдугаар багц: Жимс жимсгэнэ*

*Гуравдугаар багц: Сүү сүүн бүтээгдэхүүн*

**Хамрагдах сургуулийн хүүхдийн тоо:** Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль-625

**1-р багцад тавигдах шаардлага: Гурилан бүтээгдэхүүнд** Боов боорцог байх ба норм нормативаар өгөгдсөн илчлэг бүхий хэмжээгээр хүүхэд бүрт 80гр байна. 1 өдөрт хамрагдах хүүхдийн тоо 620-625

Бүтээгдэхүүнийг бэлтгэх явцад түүхий эдэд сахар орлуулагч зэрэг хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болох зүйлсийг оруулахгүй.

Стандартын шаардлага хангасан сайн чанарын гурил, элсэн чихэр зөгийн бал зэрэг түүхий эдээр хийгдсэн байна. Мөн хүүдэд өгч болох, стандарт орц нормд тохирсон шинэ төрлийн боорцог, байж болно. Түүнийгээ холбогдох стандартын байгууллагаар шинжилгээ лабораторид хамруулж дүгнэлт гаргасан бичгийг авч ирэх. **Жич: Хөөлгөгчгүй коврижкан төрлийн боорцог байна.**

**2-р багцад тавигдах шаардлага: Жимс жимсгэнэд** Хүүхдийн эрүүл ахуй, шаардлагад тохирсон олон төрөлт жимс, жимсгэнэ жимсний шүүс нь амин дэмийн агууламж өндөртэй байх. Жимс жимсгэнэ болон шүүс нь зориулалтын саванд савлагдсан чанарын шаардлага хангасан холбогдох байгууллагын шинжилгээнд хамрагдсан бичигтэй байх шаардлагатай. Жимс тарьсан болон гадаадаас оруулж ирсэн гарал үүслийн бичиг он сар өдөр тодорхой байх.

**3-р багцад тавигдах шаардлага. Сүүнд тавигдах шаардлага:** Сүү нь шаардлагатай шинжилгээнд хамрагдсан стандартын дагуу байна.

Аарцанд тавигдах шаардлага: Шинжилгээнд хамрагдсан малын сүүгээр монгол аргаар хийгдсэн боз биш аарц байна. **Жич: Гурил холихгүй**

**Тараганд тавигдах шаардлага:** Шаардлагатай шинжилгээнд хамрагдсан малын сүүгээр хийгдсэн хүүхдэд хэрэгтэй стандарт илчлэг нормыг хангасан байна.

**Хоормогт тавигдах шаардлага:** Шаардлагатай шинжилгээнд хамрагдсан малын сүүгээр хийгдсэн хүүхдэд хэрэгтэй стандарт илчлэг нормыг хангасан байна.

**Сүүтэй будаа, Сүүтэй каш, Сүүтэй овьёс, зөгийн балтай сүү, хийцтэй цай, луувантай сүүнд тавигдах шаардлага:** Шаардлагатай шинжилгээнд хамрагдсан малын сүүгээр хийгдсэн хүүхдэд хэрэгтэй стандарт илчлэг нормыг хангасан байна

**Жич: Захиалагч нь сүү, сүүн бүтээгдэхүүнийг илүү сонгоно.**

Тендерт ялсан тохиолдолд 01 сарын 21 ноос үдийн цайгаар үйлчилж эхлэх бөгөөд бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулсан байх шаардлагатай.

## БАРАА НИЙЛҮҮЛЭЛТ

1. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:** Бүтээгдэхүүнийг хүүхдийн тоогоор ажлын өдөр бүр хүлээн авах ба шаардлагатай тоогоор өглөө бүр захиална. Бүх нийтийн амралтын өдөр болон зайлшгүй шийдвэрээр сургууль амарсан хугацаанд захиалгыг хаана. Бүтээгдэхүүний тээвэрлэлтийн зардлыг нийлүүлэгч хариуцах ба өдөр бүр захиалсан хэмжээгээр түгээгч хүлээн авна.
2. **Тавигдах бусад шаардлага, хяналт:** Бүтээгдэхүүний орц норм болон тендерийн шаардлага, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн явцад захиалагчийн зүгээс хэсэгчилсэн болон бүрэн хяналт шалгалтыг хийж дүгнэлт хийж байна.

Бүтээгдэхүүн бүрийн хугацаа тодорхой, зориулалтын савалгаатай байна, үйлдвэрлэгчийн ажилтнуудын шинжилгээний бичиг хавсаргасан байна.

**Үйлдвэрлэлийн орчинд тавигдах шаардлага:** Үйлдвэрлэгч нь зориулалтын байр савтай байна. Тоног төхөөрөмж нь зориулалтын, ариун цэвэрийн шаардлагыг хангасан байна.

3. **Баглаа, боодол:** Барааг захиалагч хүлээн авах хүртэл баглаа боодол стандартын шаардлага, эрүүл ахуйг хангасан байна.
4. **Бараа хүргэх газар :** Увс аймаг Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль